



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 311

Улаанбаатар хот

Удирдамж болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Авлигатай тэмцэх газрын 2023 оны "Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан тухай" 05/9667 дугаар дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Булган АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг удирдамж болгосугай:

1.1. "Булган АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал Э.Пүрэвдэмбэрэлийг өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаас нь чөлөөлж, түүнтэй байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу цуцлах;

1.2. "Булган АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирлаар М.Нуваантаяыг холбогдох хууль тогтоомжийн дагуу түр томилж, Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ